

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.99

|   |           |
|---|-----------|
| Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага | MNS: 2024 |
| The General Requirements for protection and recovery services for child victim of sexual abuse              |           |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны .... дүгээр сарын ...-ны өдрийн .....дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг 2025 оны ....дүгээр сарын .....-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## 1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэхэд оршино.

## 2 Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэ стандартыг төрийн болон төрийн бус, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд (цаашид “хохирогч хүүхэд” гэх)-д хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, мөрдөн шалгах байгууллага, прокурор, шүүхээс бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хүүхдийг эрхийг хангахад дагаж мөрдөнө.

## 3 Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ.

## 4 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад заасан нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

### 4.1

#### Хүүхэд

18 нас хүрээгүй хүн бүр

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.3-д заасныг

### 4.2

#### Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг

### 4.3

#### **Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл**

аливаа этгээд хүүхдийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг

#### **4.4**

##### **Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч хүүхэд**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 д заасныг

#### **4.5**

##### **Хүүхэд аюултай нөхцөл байдалд орох**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн Тайлбар хэсэгт заасныг

#### **4.6**

##### **Хүүхэд хамгааллын үйлчилгээ**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 4.1.9-д заасныг

#### **4.7**

##### **Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.2-т заасныг

#### **4.8**

##### **Аюулгүй байдлыг хангах**

хохирогч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүйг хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээ

#### **4.9**

##### **Эмнэлгийн яаралтай тусламж**

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 –т заасныг

#### **4.10**

##### **Түр хамгаалах байр**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 5 дугаар бүлгийн 5.1.5-д заасныг

#### **4.11**

##### **Заавал мэдээлэх үүрэг**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д заасныг

#### **4.12**

##### **Кейс менежмент**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 4.1.13-д заасныг

#### **4.13**

##### **Кейс хэлэлцүүлэг**

Хүүхдийн кейс менежментийн явцыг хэлэлцэх салбар дундын төлөөлөл оролцсон албан ёсны уулзалт

#### **4.14**

##### **Мөрдөн шалгах ажиллагаа**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр бүлгийн 1.9-д заасныг

#### **4.15**

##### **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр бүлгийн 1.36-д заасныг

#### **4.16**

##### **Гэмт хэргийн талаар хүүхэдтэй хийх ярилцлага**

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоонд салбар дундын хамтарсан багаас шийдвэр гаргахад шаардлагатай гэмт хэргийн талаарх мэдээллийг хүүхдээс авах зорилгоор хийж буй ярилцлага

#### **4.17**

##### **Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам**

хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчаас мэдээллийг цуглуулах, ашиглах, хуваалцах (аман, бичгээр, электрон), хадгалах хэм хэмжээг тодорхойлсон баримт бичиг

#### **4.18**

##### **Нийгмийн ажилтан**

сум, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажлын үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн

#### **4.19**

##### **Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн**

сэтгэцийн эмч, сэтгэл засалч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан

#### **4.20**

##### **Эмнэлгийн мэргэжилтэн**

Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.5-д заасныг

#### **4.21**

##### **Хамтарсан баг**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 5 дугаар бүлгийн 5.1.4-д заасныг

#### **4.22**

##### **Нэг цэгийн үйлчилгээ**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 5 дугаар бүлгийн 5.1.3-д заасныг

#### **4.23**

##### **Хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр 4.1.14-д заасныг

#### **4.24**

##### **Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр 4.1.10-д заасныг

#### **4.25**

##### **Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ**

Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.3-д заасныг

#### **4.26**

##### **Эрүүл мэндийн байгууллага**

Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.4-д заасныг

#### **4.27**

##### **Эрүүл мэндийн ажилтан**

Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.6-д заасныг

#### **4.28**

##### **Холбон зуучлах үйлчилгээ**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 5 дугаар бүлгийн 5.1.7-д заасныг

#### **4.29**

##### **Таниулсан зөвшөөрөл**

зөвшөөрөл өгөх чадамж бүхий хүний мэдээлэл дээр тулгуурлан сайн дураар өгсөн зөвшөөрөл

#### **4.30**

##### **Мөрдөгч**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр бүлгийн 1.8-д заасныг

#### **4.31**

##### **Шинжээч**

Шүүх шинжилгээний тухай хуулийн 4.1.4-т заасныг

### **5 Хохирогч хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үед баримтлах зарчим**

5.1.1 Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах;

5.1.2 Хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах;

5.1.3 Хүүхдийн нэр төрийг хамгаалж, хүндэтгэлтэй хандах;

5.1.4 Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.5 Хүүхдийн оролцоог хангах, чадваржуулах;

5.1.6 Салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан цогц үйлчилгээ үзүүлэх;

### **6. Байгууллагад тавигдах нийтлэг шаардлага**

6.1. Байгууллага нь хүүхэд хамгааллын бодлоготой байх ба үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

6.2. Төрийн бус байгууллага нь төрийн эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн байна.

6.3. Байгууллага нь мэргэжилтнүүдээ хохирогч хүүхэдтэй харилцах, үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах болон бусад байгууллагатай хамтран ажиллах талаар арга зүйн сургалтанд тогтмол хамруулна.

6.4. Байгууллага нь хохирогч хүүхэдтэй ажиллах, түүнд үйлчилгээ үзүүлэх аюулгүй, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.

6.5. Байгууллага нь хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар гомдол, мэдээллийг харьяа орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага, эсхүл хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаар, цагдаагийн 107 тусгай дугаарт шилжүүлэх талаар тодорхой заавартай байна.

6.6. Байгууллага нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэргэжилтнүүдийн үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэлтэй харьцах эрх, үүргийг тусгасан дотоод журам, заавар хэрэгжүүлдэг байна.

6.6.1. Байгууллага нь хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар гомдол, мэдээлэл, хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээлэл алдагдах, засварлах, устгах боломжийг хязгаарласан байна.

6.7. Байгууллага хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэх мэргэжилтэн, ажилтан авахдаа ажил горилогчоос өмнө нь хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, эрүүгийн шийтгэл хүлээсэн эсэх лавлагаа шаарддаг байна.

6.8. Байгууллага нь хүүхэдтэй уулзалт хийх, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх өрөөтэй байна.

6.9. Байгууллагын мэргэжилтнүүдийн гаргасан хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зүй бус үйдлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах мэдээллийн журамтай байх ба мэдээллийг нэрээ нууцалж өгөх сонголтыг бүрдүүлсэн байна.

6.10. Мөрдөн шалгах байгууллага, прокурор, шүүх, шүүх шинжилгээний байгууллагын байранд хүүхдээс мэдүүлэг, тайлбар авахдаа хүүхдийн нас, хүйс, сэтгэхүйн онцлогт тохирсон тусгай өрөөнд гүйцэтгэнэ.

6.11. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь бэлгийн хүчирхийллийн кейс менежментийг хэрэгжүүлэх тусгай удирдамж, заавар боловсруулан мөрддөг байна.

6.12. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хохирогч хүүхдийг холбон зуучлах үйлчилгээний зураглалтай байх ба мэргэжилтнүүдээ холбон зуучлах үйлчилгээг зураглалын дагуу үзүүлэхэд сургаж бэлтгэн, хяналт тавьдаг байна.

6.11.1. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь холбон зуучлах үйлчилгээний хүрээнд хамтран ажиллах байгууллагын жагсаалттай байна.

6.13. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь мэргэжилтнүүддээ зориулсан ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинжэд өртөхөөс урьдчилан сэргийлэх стресс менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

6.14. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь мэргэжлийн удирдлагын хүрээнд кейс шийдвэрлэлтэд үүссэн бэрхшээл, алдаа дутагдлыг нэн даруй арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

6.15. Салбар дундын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд олон салбарын мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.

## **7. Хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх ажилтан, мэргэжилтэн, албан хаагчид тавигдах нийтлэг шаардлага**

7.1. Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байна.

7.2. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах талаар 16 ба түүнээс дээш цагийн сургалтанд хамрагдсан байна.

7.3. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомж, тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журам, стандартын талаар мэдлэгтэй, тэдгээрийг мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чадвартай байна.

7.4. Хүүхдэд өөрийн мэргэжлийн хүрээнд тусламж, үйлчилгээ үзүүлж, эцэг эх, гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах чадвартай байна.

7.5. Хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх хүрээнд бусад мэргэжилтнүүд (эмч, цагдаа, сэтгэл зүйч, хууль, өмгөөлөгч, багш, нийгмийн ажилтан зэрэг) -ээс зөвлөгөө, дэмжлэг авах, хамтарч ажиллах чадвартай байна.

7.6. Хүүхдийн кейсийг хариуцан ажиллах мэргэжилтэн нь бэлгийн хүчирхийллийн **өвөрмөц онцлогыг таньж илрүүлэх**, кейс менежментийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд тулгарах саад бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэх чадвартай байна.

7.7. Хүүхдийг бусад үйлчилгээнд аюулгүй, нууцыг хадгалан холбон зуучлах талаар бэлтгэлтэй байна.

7.8. Хүүхдийн амиа хорлох эрсдэлийг үнэлэх, сэрэмжлүүлэх шинж тэмдгийг таних, эрсдэлтэй тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар сургалтанд хамрагдаж бэлтгэгдсэн байна.

7.9. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар гомдол, мэдээлэл өгөхөөр хандсан тохиолдолд А хавсралтанд заасан анхан шатны дэмжлэг үзүүлэх чадвартай байна.

7.10. Хүүхдийн эрхийг хүндэтгэх, сэтгэцийн гэмтэлд суурилах, давуу талд тулгуурлах, оролцоог, хохирогч/даван туулагч төвтэй ажиллах арга зүйг эзэмшсэн байна.

7.11. Хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд дараах итгэл үнэмшил, хандлагыг баримтлан ажиллана. Үүнд:

7.11.1. хүүхэд дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг хүртэх тэгш эрхтэй,

7.11.2. хүүхэд бүрийн хэрэгцээ, давуу ба сул тал, чадамж ялгаатай бөгөөд онцлогтой,

7.11.3. бэлгийн хүчирхийлэлд өртсний дараа хүүхэд бүрийн үзүүлэх хариу үйлдэл өөр,

7.11.4. хүүхэд мэдээллээр хангагдах, мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах эрхтэй.

7.12. Хүүхэд, эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй харилцахдаа мэдээллийг тэдний нас, хөгжлийн түвшин, танин мэдэхүйн чадвар, хөгжлийн бэрхшээл, ялгаатай хэрэгцээ, эрх зүйн чадамжид тохируулан хүргэж харилцах чадвартай байна.

7.13. Хүүхэд, эцэг эх, гэр бүлийн гишүүдэд чанартай, үр дүнтэй тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой онол, практикт нэвтэрч буй шинэ арга, туршлагаас байнга суралцаж мэргэжлийн ур чадвар, арга туршлагаа тасралтгүй хөгжүүлдэг байна.

7.14. Хамтран ажиллагчаа хүүхэдтэй хувийн харилцаа тогтоосон эсвэл бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэж сэжиглэж байвал нэг байгууллагад ажиллаж байгаа эсэхээс үл хамааран мэдээлэх үүргээ ухамсарласан байна.

7.15. Үйлчлүүлэгч Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол орчуулагч, хэлмэрчийг заавал байцуулж, хамтран ажиллана.

7.16. Хүүхэдтэй ажиллах үедээ болон дууссаны дараа эсвэл ажлаас чөлөөлөгдсний дараа ч хохирогчийн нууцыг хадгалах үүрэг хүлээнэ.

## **8. Хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх**

8.1. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй мэдээлэл

хүлээн авсан байгууллагын мэргэжилтэн хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нэн тэргүүнд анхаарал хандуулж, шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэхэд анхаарч ажиллана.

8.2 Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учруулах эрсдэлтэй үед аль ойр эмнэлгийн хүлээн авах яаралтай тусламжийн тасагт боломжтой унаагаар шуурхай хүргэнэ. Эсвэл түргэн тусламж яаралтай журмаар дуудна.

8.2.1. Энэ үед хүүхдийг яаралтай тусламжийн үйлчилгээнд шилжүүлэх шаардлагыг хүүхдэд тайлбарлаж өгнө.

8.2.2. Хүүхдэд А хавсралтанд заасан анхан шатны дэмжлэг үзүүлж харилцана.

8.3. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн даруйд, эсвэл 120 цагийн дотор хандсан тохиолдолд шүүхийн шинжилгээ хийлгэх, эмнэлгийн байгууллагад хандаж өвөрмөц урьдчилан сэргийлэх эмчилгээ<sup>1</sup> авах ажлыг шуурхай зохион байгуулна. Үүнд:

8.3.1. Хэрэг гарснаас хойш 120 цагийн дотор буюу 5 хоногийн дотор ирсэн бол яаралтай жирэмслэлтээс сэргийлэх эм, эмчилгээг санал болгоно.

8.3.2. Амаар, үтрээ болон шулуун гэдсээр бэлгийн хавьталд орсон, ялангуяа лабораторийн шинжилгээ хийлгэх боломжгүй нөхцөлд заг хүйтэн, хламид, тэмбүүний эмчилгээг санал болгоно.

8.4. Шүүх эмнэлгийн нотлох баримт цуглуулах үүднээс цагдаагийн ажилтан, эмч, нийгмийн ажилтан хүүхдийг дагуулан орон нутгийн шүүх шинжилгээний байгууллагад дагалдан явна.

8.5. Хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн болон шүүх шинжилгээнд оруулсны дараа сэтгэл зүйн тусламж, үйлчилгээнд хамруулна.

8.6 Хүүхэд амиа хорлох эрсдэлтэй байж болзошгүй болон бусад сэтгэл зүйн ноцтой хямралууд илэрсэн тохиолдолд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн даруй холбон зуучилж хамруулна.

8.7 Хүүхдийн амиа хорлох эрсдлийг үнэлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох журам<sup>2</sup>-ыг баримтална.

8.8 Хүүхдэд тохиолдсон бэлгийн хүчирхийлэл 120 цагаас өмнө болсон ба хүүхдийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учраагүй тохиолдолд гэмтлийн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төв зэрэг хүүхдийн харьяаллын эрүүл мэндийн байгууллагад холбон зуучилна.

8.8.1 Энэ үед хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл өгнө.

8.8.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хаанаас, хэзээ хэрхэн авах талаар шийдвэр гаргахад хүүхдийн саналыг авч сонголтыг хүндэтгэнэ.

8.9 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар мэдээлэл хүлээн авсан мэргэжилтэн бэлгийн хүчирхийлэл үйлдэгдсэн орчинд байгаа бусад хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

8.10 Мэдээлэл хүлээн авсан мэргэжилтэн багийн ахлагч буюу мэргэжлийн удирдагчид заавал мэдэгдэж, арга зүйн дэмжлэг заавар авна.

8.11 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаар өөрөө болон хэн нэгэн мэдээлээгүй ч хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүйг тодорхой

<sup>1</sup> Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/305 дугаар тушаалын хавсралт. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж, үйлчилгээ авах заавар Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/387 дугаар тушаалын хавсралт. Үр хөндөлтийг зохицуулах журам.

<sup>2</sup> Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/149 дугаар тушаалын хавсралт. Амиа хорлохыг завдсан хүүхэд, өсвөр насныханд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар

шинж тэмдгээр (БЗДХ, жирэмслэлт ба бэлэг эрхтэн орчмын хөхрөлт, зулгаралт гэх мэт) тааварлан сэжиглэж буй тохиолдолд холбогдох мэргэжилтэн хүүхэдтэй аюулгүй байдал, нууцлалыг хангасан орчин нөхцөлд уулзан ярилцаж бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэхийг тодруулна.

8.11.1 Энэ үед хүүхэдтэй А хавсралтанд заасан удирдамжийн дагуу анхан шатны дэмжлэг үзүүлж харилцана.

8.11.2 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухай ярилцлагын явцад илчлээгүй тохиолдолд хүүхдийн нөхцөл байдлыг С хавсралтанд заасан аргачлалаар үнэлж, эрсдэл илэрсэн тохиолдолд эмнэлгийн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай тусламж үйлчилгээнд холбон зуучилна.

8.12 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг ямар ч тохиолдолд хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн байгаа болон очиж болохоор газар буцааж болохгүй.

## **9. Хүүхдийг аюулгүй байдлын хамгаалалтанд авах**

9.1. Хохирогч хүүхдийн амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйг хамгаалах арга хэмжээг Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох журамд заасны дагуу авч хэрэгжүүлнэ.

9.2. Шаардлагатай тохиолдолд хохирогч хүүхдийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох журам<sup>3</sup>-ыг баримтлан ажиллана.

9.3. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой дуудлага, мэдээллийн дагуу хүүхдийн байгаа газар очих болон эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээнд хүүхдийг хүргэх, байгууллагын үйлчилгээний орчинд хүүхдийг дагуулан явахдаа цагдаа, хүүхэд хамгааллын байгууллагын мэргэжилтнүүд хүүхдийн нэр төр, мэдээллийн нууцыг хадгалахад анхаарсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

9.3.1. дуудлагын машины дуут дохиог унтрааж очих, албаны болон тусламжийн утас 108 гэсэн лого бүхий хувцас өмсөхгүй байх

9.4. Хохирогч хүүхдийг аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд гэр бүлээс тусдаа орчинд үйлчилгээ үзүүлэхдээ MNS 6040:2019 стандарт шаардлага хангасан газар байрлуулна.

9.5. Хохирогч хүүхдийг түр хамгаалах, нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулахдаа хүүхдийн нас, хөгжлийн түвшин, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд бусад хүүхдээс тусад нь байлгаж болно.

9.6. Хүүхдийг хамгаалах байранд ирсэн даруйд хамгаалах байрны ажилтан хүүхдийг хүлээн авч уулзалт хийнэ. Үүнд:

9.6.1. хүүхэдтэй А хавсралтад заасан удирдамжийн дагуу харилцана.

9.6.2. хамгаалах байрны орчин нөхцөл, үзүүлэх үйлчилгээ, хангамж, дотоод дүрэм, байрлагчийн эрх, үүргийг тайлбарлана.

9.6.3. хүүхдэд шаардлагатай үйлчилгээний төлөвлөгөө гаргахад шаардлагатай мэдээллийг авна.

<sup>3</sup> Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаалын хавсралт



9.7. Хүүхдийг түр хамгаалан байрлуулсан газар нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг, хүүхэд хамгааллын үйлчилгээ, хууль, эрх зүйн туслалцааг зохицуулан хүргэнэ.

9.8. Хүүхдийг сэтгэл зүйн хувьд тайван байж бие махбод ба сэтгэл зүйн гэмтлээ эдгээхэд шаардлагатай орчин нөхцөлөөр хангана.

9.9. Аюулгүй байдлын хамгаалалтанд байх хугацаанд хүүхдийг нөхөн сэргээх, хөгжүүлэхэд чиглэсэн тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээнд татан оролцуулна.

9.10. Хүүхдийг гэр бүлийн орчинд нь тусламж үйлчилгээ үзүүлэх тохиолдолд хүүхэд хамгааллын байгууллагын мэргэжилтний зүгээс эцэг эх, асран хамгаалагчид зохих заавар, зөвлөгөөг өгсөн байна. Үүнд: хүүхдийг амрааж тайван байлгах, үл буруутгах, хүүхдэд цаг зав гаргаж, хамт байх, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдээ дэмжих талаар арга зүйн зөвлөгөө өгнө.

## **10. Хүүхдэд хамгааллын ба нөхөн сэргээх үйлчилгээний кейс менежментийг хэрэгжүүлэх**

10.1. Хохирогч хүүхдэд үзүүлэх шаардлагатай дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг зохион байгуулах, зохицуулах, үр дүнг эргэн хянахдаа бэлгийн хүчирхийллийн онцлогийг харгалзсан кейс менежментийн арга зүйг баримтлан хэрэгжүүлнэ.

10.2. Хүүхдэд олон салбарын мэргэжилтнүүд өөр өөрийн мэргэжлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлэх тохиолдолд холбогдох байгууллага, мэргэжилтнүүд зөвлөлдсний үндсэн дээр кейс менежментийг хариуцах кейс менежерийг томилсон байна.

10.3. Кейс менежер болон үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнүүд хүүхэдтэй ажиллах, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалан ажиллана. Үүнд:

10.3.1. хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртсний дараа бие махбод, сэтгэл зүйн хувьд аюул занал, эрсдэлд үргэлжлүүлэн болон дахин өртөхөөс хамгаалах,

10.3.2. аливаа үйлчилгээ, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхдээ хүүхдийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлыг харгалзан үзэх,

10.3.3. хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг чадваржуулах,

10.3.4. хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчтай аливаа шийдвэрийн эерэг ба сөрөг үр дагаврыг хамдаа шүүн хэлэлцэж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх,

10.3.5. хүүхдийн эдгэрэх, нийгмийн амьдралд оролцох, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх.

10.4. Бэлгийн хүчирхийллийн кейс менежментийг хэрэгжүүлэхдээ E хавсралтанд заасан удирдамжийг баримтална.

10.5. Бэлгийн хүчирхийллийн кейс менежментийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг хүүхдийн нас, хөгжлийн түвшин, хөгжлийн бэрхшээл зэрэг онцлогт тулгуурлан хэрэгжүүлнэ.

10.5.1. шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог хангах;

10.5.2. хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчөөс таниулсан зөвшөөрөл авах;

10.5.3. нууцлалын хязгаарлалтын тухай хүүхдэд хэлж тайлбарлах;

10.5.4. хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийг заавал мэдээлэх үүргийг хүүхэд, хууль ёсны төлөөлөгчид тайлбарлаж өгөх;

10.6. Кейс менежментийн явцад хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй зөвшилцсний үндсэн дээр хамтарсан шийдвэр гаргана.

10.7. Хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог хангахдаа түүний нас, хөгжлийн түвшинтэй холбоотой чадамжийг харгалзан үзнэ.

10.7.1. 7 хүртэл насны хүүхэд шийдвэр гаргахад өөрийн санаа бодлоо илэрхийлэх эрхтэй. Шийдвэр гаргах үйл явцад энэ насны хүүхдийн хүсэлт, санал бодлыг харгалзан үзэж, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр шийдвэр гаргана.

10.7.2. 7 ба түүнээс дээш насны хүүхэд ба хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр хамтран шийдвэр гаргана.

10.8. Хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх үед дараах тохиолдолд хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчөөс таниулсан зөвшөөрлийг авна. Үүнд:

10.8.1. хүүхдэд аливаа үнэлгээ, үзлэг шинжилгээ, оношилгоо хийхийн өмнө,

10.8.2. хүүхэдтэй гэмт хэргийн талаар ярилцлага хийхийн өмнө,

10.8.3. хүүхдийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах тохиолдолд,

10.8.4. хүүхдийг төлөөлөн ямар нэгэн үйл ажиллагаа явуулахын өмнө,

10.8.5. хуульд заасан бусад.

10.9. Таниулсан зөвшөөрлийг авахдаа хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн түвшнээс хамаарч дараах удирдамжийг баримтална.

10.9.1. 0-5 насны хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөс таниулсан зөвшөөрлийг бичгээр авна.

10.9.2. 6-11 насны хүүхдэд мэдээллийг нас, сэтгэхүйн хөгжлийн түвшинд тохируулан тайлбарлаж өгөхийн хамт хууль ёсны төлөөлөгчөөс таниулсан зөвшөөрлийг бичгээр авна.

10.9.3. 12-15 насны хүүхдэд мэдээллийг бүрэн тайлбарлаж өгөх ба хууль ёсны төлөөлөгчөөс таниулсан зөвшөөрлийг бичгээр авна.

10.9.4. 16 ба түүнээс дээш насны хүүхдээс өөрөөс нь ба хууль ёсны төлөөлөгчөөс таниулсан зөвшөөрлийг бичгээр авна.

10.10. Хүүхэд, хууль ёсны төлөөлөгчөөс таниулсан зөвшөөрлийг авахдаа мэргэжилтэн дараах мэдээллийг хүүхдийн нас, төлөвшил, хэл ярианы чадвар, эрх зүйн чадамжид тохируулан өгч, ойлгосон эсэхийг баталгаажуулна.

10.10.1. үйлчилгээ, холбон зуучлалын үйл явц, үйлчилгээ авах үед гарч болзошгүй эрсдэл, ашиг тус

10.10.2. хүүхэдтэй холбоотой ямар мэдээллийг ямар аргаар цуглуулах, тэдгээрийг хэрхэн ашиглах (ж нь зураг, бичлэг хийх эсэх)

10.10.3. мэдээллийн нууцлал ба нууцлалын хязгаарлалт.

10.11. Хүүхэд, хууль ёсны төлөөлөгчид зөвшөөрлийг сайн дурын үндсэн дээр өгөх боломж нөхцлөөр хангана

10.12. Хүүхдийн аюулгүй байдал, амь насанд шууд заналхийлсэн нөхцөл байдлаас хамгаалах шаардлага үүссэн бол таниулсан зөвшөөрлийг бичгээр биш аман

байдлаар авч болно.

10.13. Хүүхдийн нууцаа хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэхэд хязгаарлалт үүссэн бол энэ тухай кейс менежер/ажилтан хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хэлж тайлбарлана.

10.14. Дараах эрсдэл учирсан тохиолдолд хохирогч хүүхдийг нууцлалыг хангах эрхийг хязгаарлаж хүүхдэд тайлбарласны үндсэн дээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10.14.1. хүүхэд өөрийгөө гэмтээх болон амиа хорлох,

10.14.2. хүүхэд хэн нэгний халдлагад өртөх, амь насаа алдах,

10.14.3. хүүхэд хэн нэгэнд халдлага үйлдэх, эсвэл хэгний амь насанд халдах,

10.14.4. хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирснаас үүдэн эмнэлгийн яаралтай тусламжинд хамруулах шаардлагатай үед.

10.15. Заавал мэдээлэх үүргийн дагуу холбогдох байгууллага руу хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой болон бусад асуудлаар хандан мэдээлэх үедээ тухайн мэргэжилтэн хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчид дараах мэдээллийг өгч танилцуулна.

10.15.1. мэдээллийг ямар байгууллагад мэдээлэх тухай,

10.15.2. ямар мэдээллийг өгөх тухай,

10.15.3. мэдээллийг ямар арга, хэлбэрээр хүргүүлэх тухай (холбон зуучлах хуудсаар уу, утсаар уу гэх мэт),

10.15.4. мэдээлэл хүргэсний дараа ямар арга хэмжээ авч хэрэгжих тухай,

10.15.5. хүүхэд, хууль ёсны төлөөлөгчийн хуулиар олгогдсон эрхийн тухай

10.15.6. заавал мэдээлэх үүргийг тусгасан хуулийн заалтын тухай.

10.16. Заавал мэдээлэх үүргийн дагуу холбогдох албан тушаалтан, байгууллагад бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэхдээ тухайн ажилтан мэдээллийг аль болох аюулгүй, нууцлалыг хадгалсан байдлаар хүргэхэд анхаарч, эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллана.

10.17. Кейс менежментийн үед хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдийн дараах эрхүүдийг эдэлнэ гэдгийг хэлж өгсөн байна. Үүнд:

10.17.1. хүүхдэд үзүүлж буй үйлчилгээг зогсоох,

10.17.2. ямар ч үед асуулт асууж мэдээлэл авах,

10.17.3. өөр кейс менежер/ажилтан, мэргэжилтний үйлчилгээг авах хүсэлт гаргах,

10.17.4. санал болгож буй үйлчилгээнээс татгалзах,

10.17.5. өөрийн хувийг хэрэг, бусад бичиг баримтыг үзэж танилцах,

10.17.6. үйлчилгээ үзүүлж буй байгууллагын мэргэжилтэн хүүхэдтэй зүй бус харьцсан тохиолдолд гомдол гаргах.

10.18. Хүүхдэд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх явцдаа хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой мэдээллийг мэдсэн хүнд мэдээллийн нууцлалыг хадгалах талаар тайлбарлаж, энэ стандартын D хавсралт дах баталгаанд гарын үсэг зуруулна.

10.19. Хүүхдэд үзүүлэх кейс менежментийн төлөвлөгөөнд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчтэй зөвлөлдсний үндсэн дээр хүүхдэд чиглэсэн дараах үйл ажиллагааг тусгана.

10.19.1. Хүүхдэд ганцаарчилсан сэтгэл зүйн тусламж үйлчилгээ

10.19.2. Бага насны хүүхдүүдэд тоглоомын аргад суурилсан сэтгэл зүйн засал

10.19.3. Бүлгийн сэтгэл зүйн тусламж үйлчилгээ

10.19.4. Урлагийн сэтгэл засал

10.19.5. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ

10.19.6. Бусад.

10.20. Нарийн төвөгтэй, ээдрээтэй кейсийн үед хүүхдэд үзүүлэх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх асуудлаар байгууллага, мэргэжилтнүүдийн дунд кейс хэлэлцүүлэг хийх замаар хүүхдэд үзүүлэх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

10.21. Асралт гэр бүлд болон гэртээ байгаа хүүхдүүдийг тогтмол хугацаанд эргэж тойрч байна.

10.22. Кейс менежер нь хүүхдийн нууцыг хадгалахын тулд бүрэн бэлтгэл хангаж ажиллана. Үүнд:

10.22.1. Кейсийг кодлох (хэний мэдээлэл болохыг таних боломжгүй болгох)

10.22.2. Кейсийг хадгалах (цоожтой шүүгээ гэх мэт)

10.22.3. Мэдээллийг төрийн болон албан шугамаар олж мэдсэн хүнээс нууцыг хадгалах баталгаа гаргуулах

10.22.4. Эрх бүхий ажилтан, албан хаагчидтай холбогдох хууль тогтоомж, журмын дагуу мэдээлэл хуваалцах

## **11. Хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх**

11.1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг<sup>4</sup> эмч, эмнэлгийн ажилтан үйлчилгээний бусад орчноос тусгаарлагдсан орчинд нэг цэгт төвлөрсөн байдлаар үзүүлнэ.

11.2 Хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлэхдээ эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай удирдамжийг<sup>5</sup> дагаж мөрдөнө.

11.3 Эмч, эмнэлгийн ажилтан хүүхдийн эрхийг хүндэтгэн, өсвөр үеийнхний онцлогийг харгалзан, хүйсийн мэдрэмжтэй, хохирогч/датан туулагч төвтэй, сэтгэцийн гэмтэлд суурилсан арга барилаар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлнэ

11.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн үзлэг, шинжилгээний талаар хүүхдэд сайтар тайлбарлаж, түүний айдас, түгшүүрийг бууруулсны дараа үзлэг, шинжилгээ хийнэ.

11.5 Хохирогч хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэлийг эмнэлгийн бүртгэлд бүртгэхдээ хүүхдийн нэр төр, хувийн нууцыг хамгаалахад анхаарч мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

11.6 Эмнэлгийн тусламж үзүүлэх орчин, арга хэлбэрийг хүүхдийн насанд тохирсон байдлаар түүнчлэн хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжааны улмаас ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлтэй үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн

<sup>4</sup> Эрүүл мэндийн тухай хуулийн 13.4. дэх заалт: Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь өрхийн эрүүл мэндийн, эмнэлгийн мэргэшсэн, эх барихын, эмнэлгийн яаралтай, сувिलाхуйн дагнасан, түргэн тусламжийн, сэргээн засахын гэсэн төрөлтэй байна.

<sup>5</sup> Эрүүл мэндийн сайдын 2020 оны 6 сарын 30-ны А/364 дугаар тушаалын хавсралт, Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар,

байдлаар зохион байгуулж хүргэнэ.

11.7 Эмчийн зүгээс хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлэх үедээ бэлгийн хүчирхийлэлд өртснөөс үүдэлтэй өвчлөл, бэртэл гэмтэл, халдвар, жирэмслэлтийн тохиолдол байгаа эсэхийг нарийвчлан шинжилнэ.

11.7.1 Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсний улмаас жирэмсэн болсон тохиолдолд хуульд заасны дагуу аюулгүй үр хөндөлт хийх боломжийн тухай хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчтэй зөвлөлдөн шийдвэрлэнэ. Хэрвээ үр хөндөлт хийх заалт бүхий хугацаа өнгөрсөн бол ургийг тээн төрүүлэх хугацаанд жирэмсний үеийн тусламж үйлчилгээг хууль, журамд заасны дагуу үзүүлнэ.

11.8 Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч, хүүхэд хамгааллын ажилтан шаардлагатай тохиолдолд бусад мэргэжилтнүүдэд хүүхдэд учирсан бэртэл, гэмтэл, халдвар, жирэмслэлт зэрэг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээний хариу, үр дүн, дүгнэлтийг тайлбарлаж өгнө.

11.9 Хүчирхийллийн улмаас хүүхдийн эрүүл мэндэд учирсан хор хохирол, өвчин зовиур, бэртэл гэмтэл, халдварыг эмчлэх зорилгоор эмчилгээг төлөвлөн үзүүлж, эмчилгээний чанар, үр дүнд хяналт тавина.

11.10 Шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн эмчийн тусламж, үйлчилгээнд холбон зуучилна. Холбон зуучлах үйлчилгээг зохих журмын дагуу үзүүлнэ.

11.11 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний явцад хийгдсэн үзлэгийн тэмдэглэл, шинжилгээний хариу, үзүүлэлтийн баримтжуулалтыг үнэн зөв, бүрэн хийж гүйцэтгэнэ.

## **12. Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх**

12.1. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн нь илэрсэн, мэдээлэгдсэн даруйд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг мэргэжилтний зүгээс заавал үзүүлсэн байна.

12.2. Хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний үеийн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч эсвэл сэтгэцийн эмч үзүүлнэ.

12.3. Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь хохирогч/даван туулагч төвтэй, хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, сэтгэцийн гэмтэлд суурилсан арга барилаар тусламж үйлчилгээ үзүүлнэ.

12.4. Сэтгэл зүйн ба сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь бэлгийн хүчирхийллийн хохирогч/даван туулагч хүүхдэд илэрч буй цочмог хариу урвалын шинжүүд, айдас, түгшүүрийг намжаах, хүчирхийллийн дурсамжаа гадагшлуулах, тайвшрах, булчин суллах, стресс тайлах аргуудыг хүүхдийн нас, хөгжлийн түвшин, тусгай хэрэгцээнд тохируулан хэрэгжүүлнэ.

12.5. Сэтгэл зүйн ба сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь хохирогч/даван туулагч хүүхдийн хүчирхийллийг даван туулах үе шатны шинж тэмдгүүдийг ажиглаж, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч, кейс хариуцсан ажилтанд тайлбарлаж өгч хамтран ажиллана.

12.6. Хүүхдэд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтэн нь хүүхдийн сэтгэл зүйн ба сэтгэцийн эрүүл мэндийн байдалд өгсөн үнэлгээ, оношилгоог зохих ёсоор баримтжуулж, нууцлалыг хангасан орчинд хадгалахын зэрэгцээ хууль

журамд заасны дагуу бусадтай хуваалцана.

#### **14. Хүүхдэд холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх**

14.1 Кейс менежер/ажилтан нь шаардлагатай тохиолдолд хүүхдэд аюулгүй, ээлтэй, жөндөрийн мэдрэмж бүхий холбон зуучлах үйлчилгээг үзүүлнэ.

14.2 Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах хэрэгцээ үүссэн тохиолдолд түр хамгаалах байранд холбон зуучлахдаа холбогдох журмыг<sup>6</sup> баримтална.

14.3 Хүүхдэд эмнэлгийн яаралтай болон яаралтай бус тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлага гарсан тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээнд холбон зуучлахдаа холбогдох журмыг<sup>7</sup> баримтална.

14.4 Холбон зуучлах үйлчилгээний үед хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд анхаарч ажиллана.

14.5 Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэх байгууллагын тухай мэдээллээр бүрэн хангасан байна.

14.6 Холбон зуучлах үйлчилгээний үед үйлчилгээний төрөл, хэлбэр болон үйлчилгээний байгууллагатай холбоотой сонголт хийхдээ хүүхдийн оролцоог хангаж, саналыг харгалзан үзэж шийдвэрийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчтэй хамтарч гаргана.

14.7 Холбон зуучлах үйлчилгээний үед хүүхдийн хувийн мэдээлэл алдагдах, хүүхэд болсон үйл явдлыг дахин ярих шаардлага үүсэх, дахин гэмтэлд өртөх эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

#### **15. Хүүхдэд боловсрол үйлчилгээ үзүүлэх**

15.1. Хүүхдэд тасралтгүй боловсролд хамруулах ажлыг кейс менежер хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцсний үндсэн дээр зохион байгуулна.

15.2. Хүүхэд сурч байсан сургуульдаа үргэлжлүүлэн суралцах шийдвэр гаргах тохиолдолд хамтарсан багийн гаргасан нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн аюулгүй байдлыг нь бүрэн хангаж суралцуулах үйл ажиллагааг сургуультай хамтран хэрэгжүүлнэ.

15.3. Дараах тохиолдолд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр хүүхдийг сурч байсан сургуулиас өөр сургуульд шилжүүлэн суралцуулах ажлыг зохион байгуулна.

15.3.1. хүүхдэд тохиолдсон бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл, нууцлал алдагдсан,

15.3.2. нөхцөл байдлын үнэлгээгээр сурч байсан сургуульдаа үргэлжлүүлэн явах нь хүүхдэд аюултай гэж үзсэн,

15.3.3. хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүүхдийг сурч байсан сургуульдаа үргэлжлүүлэн суралцуулахаас татгалзах.

<sup>6</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/39 тоот тушаалын хавсралт, Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам,

Улсын Ерөнхий Прокурор, Хууль зүйн сайдын 2017 оны А/22, А/31 тоот хамтарсан тушаалын хавсралт Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам

<sup>7</sup> Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 тоот тушаалын хавсралт. Хохирогчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам.

15.4. Хамгаалах байранд байгаа хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг тухайн байгууллага хариуцан ажиллаж, хамгаалах байрны ойр байршилтай болон хамтын ажиллагаатай бусад сургуульд шилжүүлэн сургах ажлыг зохион байгуулна.

15.5. Сургууль завсардсан, эсвэл сургуульд огт сураагүй хүүхдийг холбогдох журмын<sup>8</sup> дагуу боловсрол нөхөн олгох сургалтанд хамруулна.

15.6. Хүүхэд жирэмсэн, төрсөн, хөхүүл тохиолдолд хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй зөвшилцсний үндсэн дээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр сургалтыг зохион байгуулах ажлыг хүүхдийн суралцаж буй сургуультай хамтран хэрэгжүүлнэ.

15.7. Хохирогч хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой мэдээллийг сургуулийн суралцагчид, багш, ажилтан, эцэг эх зэрэг оролцогч талуудаас нууцлах буюу мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах талаар кейс менежер, сургуулийн хүүхэд хамгааллын баг хамтран хариуцлагатай ажиллана.

15.8. Хүүхдийн бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой мэдээллийг мэдсэн сургуулийн багш, ажилтан, оролцогч талуудад мэдээллийн нууцлалыг хадгалах талаар тайлбарлаж, энэ стандартын D хавсралт дахь баталгаанд гарын үсэг зуруулна.

## **16. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлтэй ажиллах**

16.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтний зүгээс хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлтэй ажиллахдаа хүчирхийлэл үйлдэгч нь хүүхэдтэй нэг гэр бүлийн гишүүн, төрөл садны холбоотой эсэхийг харгалзан үзэж ялгаатай арга барилаар ажиллана.

16.2. Хүчирхийлэл үйлдэгч нь хүүхэдтэй төрөл садны холбоогүй тохиолдолд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй уулзаж, уулзалтын үед дараах мэдээлэл, зөвлөгөөг өгнө. Үүнд:

16.2.1. хүүхдэд тохиолдсон бэлгийн хүчирхийлэл, түүний сөрөг үр дагавар, хүүхдэд илэрч болох шинж тэмдэг, гэмтлийн дараах стрессийн хам шинжийн тухай,

16.2.2. хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйл, сэтгэл зүйн байдлын тухай мэргэжилтнүүдийн дүгнэлт,

16.2.3. тохиолдсон хэрэгт хүүхдээ ба өөрсдийгөө буруутгахаас илүү харилцан бие биеэ дэмжих,

16.2.4. хүүхдэд дахин гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх,

16.2.5. хүүхэддээ хэрхэн дэмжлэг үзүүлж, үр дүнтэй харилцах,

16.2.6. хүүхдээ нас, хөгжлийн онцлогт тохирсон хөгжлийг дэмжих үйлчилгээ, үйл ажиллагаанд хамруулах,

16.2.7. хүүхдийн өдөр тутмын амьдралыг хэвийн (тогтмол цагт унтуулах, тэжээллэг хоол хүнсээр хангах гэх мэт) үргэлжлүүлэх,

16.2.8. хүүхдэд хийж буй эмчилгээ, үйлчилгээний удирдамж, зааврыг дагаж мөрдөх.

16.3. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч ба гэр бүлийн бусад гишүүд

<sup>8</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт, Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам

болсон үйл явдалд хүүхдийг болон өөрсдийгөө буруутгах, хоорондоо зөрчилдөх зэрэг сэтгэл зүйн тулгамдсан асуудалд өртсөн бол сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд хамруулна.

16.4. Шаардлагатай тохиолдолд эцэг эх ба хүүхдийн хооронд уулзалт хийх арга хэмжээг төлөвлөн, удирдаж явуулж хүүхэд, эцэг эхийн харилцан ойлголцлыг дэмжин ажиллана.

16.5. Архи, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийг зан үйлийн өөрчлөлтийн тусгай хөтөлбөрт хамруулна.

16.6. Шаардлагатай тохиолдолд хүүхдийн гэр бүлд чиглэсэн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

16.6.1. Амьжиргааны түвшин доогуур, олон хүүхэдтэй өрхийг өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрт хамруулах,

16.6.2. Хүмүүжлийн эерэг аргын сургалтанд хамруулах.

## **17. Хүүхдэд хууль ёсны төлөөлөгч томилох нь**

17.1. Мөрдөгч дараах нөхцөл байгаа тохиолдолд төрсөн, үрчилж авсан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хүүхэдтэй ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилохгүй. Үүнд:

17.1.1. хүүхдэд тохиолдсон хүчирхийллийн талаар мэдсэн ч заавал мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй;

17.1.2. хүүхдээс болсон явдлын талаар дуугүй байх, нуухыг шаардсан, гуйсан, тухайн үйл явдлыг өөр байдлаар ойлгуулах зэргээр нөлөөлсөн;

17.1.3. хүүхдийг буруутгаж, гэр бүлийн нэр төр, харилцааг илүү чухалчилж буй;

17.1.4. хүчирхийлэл үйлдэгчээс сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хараат;

17.1.5. хүүхдийн эрх ашгийг хамгаалах, сэтгэл зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх чадваргүй.

17.2. Хүүхдийн төрсөн, үрчилж авсан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь байхгүй, эсхүл дээр дурдсан нөхцөл байдал тогтоогдсон бол хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр томилно.

17.3. Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь хүүхдийн эрх ашгийг төлөөлөх үүрэг хариуцлагаа ухамсарлаж, дараах үүргийг хүлээн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.

17.3.1. хүүхэдтэй холбоо тогтоож, итгэлцэл бий болгон харилцах,

17.3.2. хүүхдийн сэтгэл зүй, бие махбод эрүүл мэндийн байдалд санаа тавих,

17.3.3. хүүхдийн эрх ашгийг хамгаалан тууштай, санаачилгатай ажиллах,

17.3.4. гэмт хэргийн улмаас хүүхдэд учирсан хор хохирлыг нэхэмжлэх

17.3.5. хуульд заасан бусад.

17.4. Хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон ажилтныг тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд тогтвортой ажиллах бололцоогоор хангана.



## **18. Шүүх шинжилгээний үед хүүхдийн эрхийг хангах нь**

18.1. Хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд шинжилгээ хийх шинжээч нь хүүхдийн эрхийг хүндэтгэсэн сэтгэцийн гэмтэлд суурилсан байдлаар хүүхэдтэй харилцаж, үйлчилгээ үзүүлнэ.

18.2. Шинжээч нь хүүхдийн бие, сэтгэл зүйд шинжилгээ хийхдээ дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

18.2.1. Хийгдэх үзлэг, шинжилгээний талаар хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч, эсхүл хүүхдийг дагуулж яваа хүнд сайтар тайлбарлаж, хүүхдийн айдас, түгшүүрийг намдааж тайвшруулна.

18.2.2. Хүүхдэд хийх шинжилгээтэй холбоотой тодруулах зүйл байгаа эсэхийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчөөс асууж, бүрэн дүүрэн хариулт өгнө.

18.2.3. Үзлэг шинжилгээг холбогдох удирдамж, зааврын дагуу гүйцэтгэнэ.

18.3. Шүүх шинжилгээний үр дүн, тэмдэглэлийг байгууллагын бүртгэлд бүртгэхдээ хүүхдийн нэр төр, хувийн нууцыг хамгаалахад анхаарч мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

18.4. Шүүх шинжилгээ хийх орчин, арга хэлбэрийг хүүхдийн насанд тохирсон байдлаар, түүнчлэн хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжааны улмаас ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлтэй үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн байдлаар зохион байгуулж хүргэнэ.

18.5. Шүүх шинжилгээний үед хүүхдийн биеийн хэсгийн зураг, бичлэгийг хийх шаардлага гарч болзошгүй бол энэ талаар хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид урьдчилан мэдээлж, таниулсан зөвшөөрөл авсан байна.

## **19. Мөрдөн шалгах ажиллагааны үед хүүхдийн эрхийг хангах нь**

19.1. Олон нийтийн ашиг сонирхол, эрх зүйн боловсрол олгох, хүүхэд хамгааллын нөлөөллийн ажлын зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэргийн талаар мэдээлэх бол мэдээллийг хүүхдэд хамаатуулах боломжгүй болгоно.

19.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хэрэгт холбогдолтой байж болзошгүй эцэг, эх, гэр бүлийн гишүүд болон бусад этгээдийн дарамт, шахалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоход чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

19.2.1. хүүхэд хүчирхийлэл үйлдэгч, түүний хамаарал бүхий этгээдтэй хууль, цагдаа, шүүхийн байгууллага ба бусад орчинд тааралдах эрсдлээс урьдчилан сэргийлэх,

19.2.2. хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдээс олон дахин мэдүүлэг авахыг хязгаарлах.

19.3. Хүүхдээс мэдүүлэг авахын өмнө Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.3-д заасан ажиллагааг гүйцэтгэсэн байна.

19.4. Шаардлагатай тохиолдолд мэдүүлэг авахаас өмнө хүүхдийг сэтгэл зүйчтэй уулзуулсан байна.

19.5. Хүүхэд мэдүүлэг өгөх бүрт бичлэг хийж хадгална.

## **20. Гэмт хэргийн талаар хүүхэдтэй ярилцлага хийх**

20.1. Хэргийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай гэмт хэргийн мэдээллийг хүүхдээс авах зорилгоор тусгай ярилцлагыг хийж болно.

20.2. Энэ ярилцлагыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо буюу түүний ажлын албаас зохион байгуулж, мөрдөгч эсвэл хөндлөнгийн мэргэжилтнээр удирдан явуулна.

20.3. Хүүхэдтэй гэмт хэргийн талаар олон давтан ярилцлага хийхээс урьдчилан сэргийлэх үүднээс хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бүхий л мэдээллийг энэ ярилцлагаар олж мэдэхийг зорино.

20.4. Ярилцлагыг хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохируулан, соёлын ба жендэрийн мэдрэмжтэй, бодит баримт, нотолгоог эрэлхийлсэн, хуульд нийцсэн байдлаар хөтлөн явуулна.

20.5. Хүүхэд хийх ярилцлагын хугацааг хүүхдийн наснаас хамааруулан дараах байдлаар тогтоож, шаардлагатай тохиолдолд тогтоосон хугацааны дараа завсарлага авах байдлаар ярилцлагыг үргэлжлүүлнэ.

20.5.1. 9 хүртэл насны хүүхэдтэй хийх ярилцлагын үргэлжлэх хугацаа 30 минутаас хэтрэхгүй,

20.5.2. 10-14 насны хүүхэдтэй хийх ярилцлагын үргэлжлэх хугацаа 45 минутаас хэтрэхгүй,

20.5.3. 15-17 насны хүүхэдтэй хийх ярилцлагын хугацаа нэг цагаас хэтрэхгүй.

20.6. Хүүхэдтэй гэмт хэргийн талаар хийх ярилцлагыг В хавсралтад заасан удирдамжийн дагуу явуулна.

## **21. Хориглох зүйл**

**21.1. Хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх болон мөрдөн шалгах ажиллагааны байгууллага, прокурор, шүүхийн ба шүүх шинжилгээний байгууллагад дараах зүйлийг хориглоно.**

21.1.1. Хүүхдийг түр хамгаалан байрлуулах үед бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг насанд хүрсэн хүн, хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхэдтэй хамт байлгах,

21.1.2. Эмнэлэг, шүүх шинжилгээний байгууллага хүүхдэд шаардлагагүй нэмэлт үзлэг, шинжилгээг хийх,

21.1.3. Мөрдөн шалгах ажиллагааны байгууллага, прокурор, шүүх нь хүүхдэд зориулсан өрөөг зориулалтын бусаар ашиглах,

21.1.4. Байгууллага мэргэжилтэн, албан хаагчдынхаа хүүхэдтэй зүй бус харьцсан талаарх мэдээллийг нуун дарагдуулах,

21.1.5. Цагдаа, хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлагын машин хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөнтэй холбоотой дуудлага, мэдээллийн дагуу хүүхдийн байгаа газар очихдоо дуут дохио хэрэглэх зэргээр хүүхдийн нэр төрд шууд бусаар халдах,

21.1.6. Хүүхэд хамгааллын байгууллага хохирогч хүүхдийг эмнэлгийн яаралтай тусламж болон нийгмийн бусад тусламж үйлчилгээнд хүргэж өгөх, авах, үйлчилгээний байгууллагын орчин, олон нийтийн газар дагуулж явахдаа албаны дүрэмт хувцас өмсөх, жишээ нь хүүхдийн тусламжийн утас 108-ын лого бүхий хувцас өмсөх,

21.1.7. Байгууллага нь хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, эрүүгийн шийтгэл хүлээсэн хүнийг байгууллагадаа ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэх,

21.1.8. Байгууллага нь хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчтэй тааралдах, тулгарах, уулзах боломж нөхцөлийг бүрдүүлэх.

**21.2. Хохирогч хүүхэдтэй харьцах, ажиллах, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэнд дараах зүйлийг хориглоно.**

21.2.1. Хүүхэд хүчирхийлэлд өртснийг мэдсэн тохиолдолд холбогдох байгууллагад заавал мэдэгдэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх,

21.2.2. Ажлын байрны сургалт, мэргэжлийн удирдагчийн зөвлөгөө, аливаа хурал, зөвлөгөөнд хамрагдах үедээ хүүхдийн мэдээллийг задруулах,

21.2.3. Хүчирхийлэл үйлдэгч талын нөлөөнд автаж, хүүхдийн эрх ашиг, сонирхлын эсрэг ажиллах,

21.2.4. Хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, гэмт хэргийн талаар ярилцах, шүүх хуралдаанд оролцох үед хүүхдээр болсон зүйлийг дэлгэрэнгүй ярих, дүрслэн үзүүлэхийг шаардах, албадан яриулах,

21.2.5. Хүүхдийн хувийн ба эмзэг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтлэх, гуравдагч этгээдэд дамжуулах,

21.2.6. Хүүхэдтэй харилцах үедээ архи, тамхи, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт болон бусад төрлийн бодис хэрэглэх,

21.2.7. Хүүхдийн хувийн орон зайнд халдах,

21.2.8. Хүүхдэд бие махбодын болон сэтгэл санааны ямар нэгэн зовиур, дарамт учруулах,

21.2.9. Хүүхэдтэй хувийн дотно харилцаанд орох,

21.2.10. Хүүхдийг нас, хүйс, үндэс угсаа, нийгмийн байдал, хэл, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхах,

21.2.11. Хамтран ажиллагчийнхаа үйлдсэн хүүхэдтэй зүй бус харьцсан тохиолдлыг мэдсэн ч нуун дарагдуулах,

21.2.12. Хүүхдийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлахгүй байх,

21.2.13. Хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх, холбон зуучлах үедээ хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчийн оролцоо, зөвшөөрөлгүйгээр дур мэдэн шийдвэр гаргах,

21.2.14. Хүүхэд өөрийгөө болон бусдыг гэмтээхээр төлөвлөж буйг мэдсэн боловч урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авахгүй байх,

21.2.15. Хүүхдэд шаардагдах үйлчилгээг үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах,

21.2.16. Мэдүүлэг авч буй этгээд 16 насанд хүрээгүй хүүхдэд хэргийн талаар мэдэх зүйлээ худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай сануулах.

**ТӨГСӨВ.**

## **А хавсралт (норматив)**

### **Мэргэжилтний зүгээс хохирогч хүүхдэд үзүүлэх анхан шатны дэмжлэг**

1. Анхааралтай сонсох (хүүхдийг ярианд анхаарал хандуулан, шүүмжлэхгүйгээр ойлгож сонсох),
2. Хэрэгцээг тодруулах (хүүхдийн санааг зовоож буй нэн тэргүүний хэрэгцээ, тулгамдсан асуудлыг тодруулж, шаардлагатай арга хэмжээ авах),
3. Баталгаажуулах (хүүхдийг ойлгож, итгэж байгаагаа харуулах, хүүхдэд буруу байхгүй гэдгийг хэлж ойлгуулах),
4. Аюулгүй байдлыг хангах (хүүхдийн эрсдлийг үнэлж, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх),
5. Дэмжлэг, туслалцаа үзүүлэх (хэрэгтэй мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэг, үйлчилгээнд хамрагдахад туслэх).

## **В хавсралт (норматив)**

### **Хүүхэдтэй гэмт хэргийн талаар ярилцлага хийх удирдамж**

#### **В.1 Ярилцлагад бэлдэх**

**В.1.1** Ярилцлагыг үр дүнтэй, амжилттай авахын тулд эцэг эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч, мөрдөгч зэрэг субъектээс хүүхдийн талаар дараах үндсэн мэдээллийг цуглуулж танилцсан байна. Үүнд:

- Хүүхдийн нийгэм, хүн ам зүйн байдал; (нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, гэр бүлийн байдал, тусгай хэрэгцээ гэх мэт)
- Өмнө нь хүчирхийлэл дарамтад өртөж байсан тухай;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байсан талаар;
- Хууль сахиулах үйл ажиллагаанд хамрагдаж байсан байдал;
- Эрүүл мэндийн түүх;
- Эмчийн үзлэгийн тэмдэглэл;
- Хүүхдийн сонирхол, хобби, суралцдаг сургууль, анги, найз нөхдийн холбоо;
- Хүүхэд ярилцлага хийх талаар ямар сэтгэгдэлтэй байгаа, үүсч болзошгүй хүндрэл.

**В.1.2** Ярилцлага хийх орчин нөхцлийг бүрдүүлнэ. Хүүхэдтэй хийж буй ярилцлагыг, орчин нөхцлийг бичиж авах зориулалттай дууны, дүрсний, дуу дүрсний бичлэг хийх төхөөрөмжөөр тоноглогдсон, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлд явуулна.

#### **В.2 Танилцах ба холбоо тогтоох**

Хүүхэдтэй танилцаж, итгэлцэл бүхий холбоо тогтооход анхаарна. Үүний тулд

**В.2.1** Хүүхэдтэй ижил түвшинд сууж харилцана. Хэрвээ хүүхэд шалан дээр сууж байвал шалан дээр суух ба сандал дээр сууж байвал хажуугийн сандал дээр тохиромжтой зайнд сууна.

**В.2.2** Хүүхэдтэй мэндэлж, түүнд өөрийнхөө нэрийг хэлэх ба хүүхдээс нэрийг нь асууна.

**В.2.3** Бага насны хүүхэдтэй холбоо тогтоохын тулд тоглоом, наадгай (хүүхэлдэй, эвлүүлдэг тоглоом, зурагтай ном, буддаг ном гэх мэт) г ашиглана. Хүүхэдтэй хамт 5-10 минут орчим тоглоно. Чи юу хийж байгаа юм бэ? Энэ хүүхэлдэй юу хийж байгаа юм бэ? Чиний зурж/будаг буй зургийг харж болох уу? гэх зэрэг асуулт асуух замаар хүүхэдтэй харилцахыг хичээнэ.

**В.2.4** Хүүхэдтэй энгийн сэдвээр хэдэн минут харилцахыг хичээнэ. (Энэ нь хүүхдийн хөгжлийн түвшин, харилцааны чадвар ба сэтгэл хөдлөлийн байдлын талаар олж мэдэхэд тусална.) Чи өнөөдөр өглөөний цайндаа юу идсэн бэ? Өнөөдөр энд юугаар ирсэн бэ? Хэнтэй хамт ирсэн бэ? Гэх зэрэг энгийн асуултыг асууж ярилцана.

**В.2.5** Сургуулийн насны ба өсвөр насны хүүхэдтэй холбоо тогтоохдоо “Би чиний тухай илүү сайн мэдмээр байна. Чи өөрийнхөө хийх дуртай зүйлийнхээ тухай надад ярьж өгч болох уу?” гэж хэлж болно.

#### **В.3 Мэдээлэл өгөх**

**В.3.1** Хүүхдэд тухайн орчны талаар болон хүүхдийг энд байлгаж байгаа зорилгын талаар танилцуулна.

Жишээ: *“Миний нэрийг .. гэдэг бөгөөд миний ажил бол хүүхдүүд аюулгүй байгаа эсэх, хэн нэгэн тэднийг өвтгөж зовоогоогүй гэдгийг мэдэх явдал юм. Хэрвээ хэн нэгэн хүн хүүхдийг өвтгөж зовоосон бол бид хүүхдийг хамгаалалтад авч, түүнд тусладаг.*

*Чи энэ газрыг олон өрөө, тасалгаатай, олон хүнтэй байгааг харсан байх. Тэгэхээр энд чам шиг хүүхдүүд, хүмүүс ирж өөрийг нь өвтгөж зовоосон үйл явдал, хүний тухай ярьдаг юм. Тэр бүх хүүхдүүдэд туслахын тулд энд над шиг олон хүн ажилладаг юм шүү дээ.*

*Чи энэ газрыг сайн мэдэхгүй ч энд чи ямар ч аюулгүй. Энд бид хэсэг хугацаанд ярилцсны дараа чи буцаад гэртээ, ээж аавдаа очно.*

**В.3.2** Хэрвээ дуу, дүрсний бичлэгийн төхөөрөмж, чихэвч зэрэг техник хэрэгсэл ашиглаж байгаа бол энэ тухай мэдээлж, яагаад хэрэглэж байгаа тухай тайлбарлана.

Жишээ: *.. Чи харж байж магадгүй энд видео камер байна. Би бас чихэвч зүүсэн байгаВ. Эдгээр нь хоёулангийн энд ярьсан яриаг бичиж авах болно. Ингэснээр би чиний хэлсэн зүйл бүрийг алдалгүй сонсох болно. Заримдаа би чиний хэлсэн зүйлийг мартчихаж магадгүй. Тэр үед бичлэгээ үзээд чамтай дахин ярихгүйгээр ярьсан зүйлийг чинь сэргээгээд мэдчихнэ гэсэн үг.*

**В.3.3** Хэрвээ дэвтэрт тэмдэглэл хөтөлж байвал энэ тухай мөн хүүхдэд дээрх маягаар тайлбарлана.

## **В.4 Зааварчилгаа өгөх**

**В.4.1** Хүүхдэд зааварчилгаа өгснөөр тааж хариулах, ярилцлага авч буй хүний асуултыг аялдан дагалдах байдал үүсэхээс сэргийлж чадна.

**В.4.2** Ярилцлагын өмнө хүүхдэд дараах гурван зааварчилгааг өгнө.

**В.4.2.1** Мэдэхгүй байгаа талаарх зааварчилгаа:

Хэрэв миний асуултанд өгөх хариултаа мэдэхгүй байвал битгий тааж хариулаарай. Мэдэхгүй гэж хэлээрэй.

Ойлгохгүй байгаа талаарх зааварчилгаа: Хэрэв миний юу асууж байгааг ойлгохгүй бол Би таны асуултыг ойлгохгүй байна гэж хариулаарай. Би асуултаа илүү ойлгомжтой асуух гэж хичээх болно.

Буруу асуулт асуусан талаарх зааварчилгаа: Миний буруу бол хэлээрэй. Заримдаа би буруу ойлгоод буруу зүйл асууж магадгүй. Тэр үед намайг буруу ярьж байгааг буюу буруу асуулт асууж байгааг хэлээрэй.

**В.4.3** Зааварчилгаа өгөх гэж буй хүүхэд бэлгийн хүчирхийллийн тохиолдлын талаар ярьж эхэлбэл зааварчилгаа хэсгийг алгасаж болно.

## **В.5 Үнэнийг мэдүүлэх**

Энэ хэсэгт хүүхдэд үнэнийг хэлэхийн ач холбогдлыг тайлбарлаж, үнэнийг хэлэх амлалт авахуулна.

Жишээ: Өнөөдөр чи надад үнэнийг ярих нь чухал юм. Чи ярилцлагын явцад үнэнийг ярина гэж амлаж чадах уу?

**В.5.1** Үнэнийг хэлэхээр хүүхдээс амлалт авах нь түүний үнэн худлыг ярих чадамжийг шалгаж буй хэрэг биш. Хүүхэд үнэнийг ярих тухай амлалт өгснөөр үнэнийг хэлэх

магадлал өсдөг.

Хүүхэд үнэнийг хэлэх амлалт өгөхөөс татгалзвал ярилцлага авч буй хүн үүний учир шалтгааныг асууж болно. Мөн үнэнийг хэлснээр учирч болох эрсдлээс айж буй тохиолдолд хүүхдэд үнэнийг хэлэхийн ач холбогдлыг таниулж, хүүхдийг хамгаалах талаар хэлнэ.

## **В.6 Ярих дадлага хийх (өгүүлэхүйн дасгал)**

**В.6.1** Чамд тохиолдсон зүйлийн талаар өөрийн санаж байгаа бүх зүйлээ надад хэлэх нь маш чухал юм. Сайн, муу аль ч зүйлийн талаар санаж байгаа зүйлээ бүгдийг нь хэлж болно.

**В.6.2** Хүүхдийн амьдралд саяхан тохиолдсон чухал үйл явдлын талаар яриулж болно.

*Жишээ нь сургуульд саяхан орсон, төрсөн өдрөө тэмдэглэсэн, ямар нэгэн тэмдэглэлт арга хэмжээ болсон бол хүүхдээ тэр тухай ярьж өгөхийг хүсч болно. Энэ талаар дараах маягаар хэлж өгнө.*

*Жишээ: Саяхан чиний төрсөн өдөр болсон тухай сонслоо. Тэгэхээр төрсөн өдрөө яаж тэмдэглэсэн талаар эргэн санаж байгаад тэр өдөр өглөө сэрснээсээ хойш орой унттал болсон бүхнийг эхнээс нь дуустал нэг ч зүйлийг орхигдуулалгүйгээр ярьж өгнө үү.*

**В.6.3** Хүүхдийг ярьж байх үед яриаг нь таслахгүйгээр сайтар сонсож, хүүхэд зогссон тохиолдолд хүүхдийн ярьж байгаад зогссон хэсгээс үргэлжлүүлэн Тэр тоглоомын тухай ярьж өгнө үү, гэх мэтээр тодруулах нээлттэй асуулт асууж, хүүхдийн хариултыг үгэн ба үгэн бус байдлаар дэмжих замаар үйл явдлыг дуустал нь яриулна. Хүүхэд төрсөн өдөр болсон зүйлийн тухай бүхэлд нь ярьж дууссаны дараа *Чи олон хүүхдүүдтэй бөмбөгөөр тоглосон тухай хэлж байсан. Тэр тоглоомын тухай илүү дэлгэрэнгүй ярьж өгнө үү гэх мэтээр ярилцана.*

**В.6.4** Хүүхдийг ярьж дууссаны дараа *Чи төрсөн өдрийнхөө талаар маш сайн ярилаВ. Тэнд байгаагүй хэдий ч би чиний төрсөн өдөр хэрхэн өнгөрсөн талаар бүгдийг мэдэж авлаа шүү дээ.* гэж хэлж болно.

## **В.7 Саад бэрхшээлийг үнэлэх**

Ярилцлага өгөхөд тулгарч буй саад бэрхшээл, ташаа ойлголтыг энэ хэсэгт илрүүлж залруулна. Ярилцлага өгч буй хүүхэд ярилцлагын зорилгыг өөрөөр ойлгосон байх, тухайлбал өөрийгөө эмч, эсвэл сэтгэл зүйчтэй ярилцаж байна гэж бодсон байж болно.

Санаа нь зовж буй зүйл байгаа эсэхийг тодруулах асуулт тавих замаар илрүүлж болно. Дараах хувилбаруудыг дагана.

*Жишээ: Үүнийг хэлсэнд баярлалаВ. Чамайг ойлгоход их дөхөм болж байна. Санааг чинь зовоож байгаа зүйлс байгаа ч чи надтай ярилцаж чадах уу?*

*Чамд санаа зовох зүйл байхгүй байгаад баяртай байна. Хэрэв дараа нь санаа зовох зүйл гарвал надад хэлээрэй.*

## **В.8 Хүүхэд өртсөн эсвэл өртсөн байж болзошгүй бэлгийн хүчирхийллийн талаар олж мэдэх**

**В.8.1** Энэ хэсэгт нээлттэй асуулт асуух замаар ярилцлагыг хөтөлнө. Хүүхдийг тохиолдлын талаар яриулахдаа дараах жишээний тохирохыг хэрэглэнэ. Үүнд:

*Жишээ:*

1. *Чиний талаар бага ч гэсэн зүйлийг олж мэдсэндээ баяртай байна. Одоо хоёулаа чи яагаад энд ирсэн тухай ярилцъя.*
2. *Чамайг “ээждээ”, “багшдаа” чамд тохиолдсон зүйлийн талаар ярьсан гэж сонслоо. Чи тэр зүйлийн талаар надад ярьж өгнө үү/ өгч болох уу?*
3. *Чиний гар хөхөрсөн, шалбарсан, хугарсан, хөл чинь бэртсэн байхыг харлаВ. Чи энэ талаар ярьж өгнө үү.*
4. *Чамайг өнгөрсөн 7 хоногт эмчид үзүүлсэн, цагдаад очсон гэж сонссон. Чи тэдэнд ярьсан зүйлийнхээ талаар ярьж өгнө үү.*
5. *Ээж чинь, багш чинь чамд тохиолдсон зүйлийн талаар санаа нь зовж байгаа юу? Ээжийнхээ, багшийн чинь санааг зовоож чамд тохиолдсон тэр зүйлийн талаар ярьж өгнө үү.*
6. *Хэн нэгэн хүн чамд муу зүйл хийсэн байна шүү дээ. Чи тэр талаар ярьж өгнө үү.*
7. *Чамайг тэнд (хамаатныхаа айлд, зусланд, бэлтгэл дээр) байхад нэг зүйл болсон гэж сонссон. Тэнд чамд тохиолдсон зүйлийн талаар ярьж өгнө үү.*

Нээлттэй асуултын дагуу хүүхэд ярьж байгаад зогсох болон өөр зүйл рүү шилжих үед Дараа нь яасан бэ гэсэн асуултын тусламжтайгаар тухайн тохиолдлыг бүрэн дүүрэн дуустал яриулахыг хичээнэ.

**В.8.2** Нарийвчилсан асуултуудыг хүүхэд ярилцагчийн асуусан нээлттэй асуултын дагуу хүүрнэл хэлбэрээр хариулж, тохиолдлын талаар бүрэн дүүрэн ярьж дууссаны дараа асууна.

**В.8.3** Хүүхэд тохиолдлыг дэлгэн хүүрнэн ярьж буй үед ярилцлага хийх удирдамжийн дагуу асуух өөр асуулт байгаа эсэхийг нягтлахаар завсарлага авч болно. Завсарлага авах талаар дараах байдлаар хэлнэ.

*Жишээ: .. Одоо бид түр завсарлага авах гэж байна. Өөр асуух асуулт байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй байгаа юм. Намайг гарч явсан хойгуур надад хэлэх нь зүйтэй гэж бодсон өөр зүйлс байгаа эсэхийг бодоорой.*

**В.8.4** Тухайн хэрэг зөрчлийг мөрдөн шалгахад цаг хугацааны мэдээлэл чухал. Тухайн хэрэг тохиолдол хэзээ болсон, хэдэн удаа үргэлжилсэн зэргийг мэдэх хэрэгтэй. Гэтэл тохиолдол олон давтамжтай болж байсан бол цаг хугацааг санахад хүнд байдаг. Энэ үед асуултыг дараах маягаар асууж болно.

*Энэ үйл явдал хэзээ болсон талаар санаж байгаа зүйлээ ярьж өгнө үү?*

## **В.9 Ярьсан зүйлийг тодруулах**

**В.9.1** Ярилцлага өгч буй хүүхэд яриагаа дуусган, ярилцагч шаардлагатай мэдээллээ олж авсны дараа хүүхдийн ярьсан зарим үг хэллэг, нэр томъёог тодруулж асууна.

*Жишээ: Энэ хэсэг эд эрхтнийг өөрөөр нэрлэдэг үү?*



*Эмч зэрэг мэргэжлийн хүмүүс энэ хэсэг, эд эрхтнийг юу гэж нэрлэдэг вэ?*

**В.9.2** Ярилцагчийн хэлж буй биеийн хэсэг, эд эрхтнийг хүүхэд хэлж чадахгүй бол хүний биеийн диаграмм, үзүүлэн дээр заалгаж болно. Ярилцлага өгч буй хүүхэд ярих зүйлээ дуусгасан бөгөөд зөвхөн түүний бие эрхтнийг нэрлэсэн үг хэллэгийг ойлгох, тодруулах үүднээс биеийн диаграмм, хүүхэлдэй ашиглана.

## **В.10 Өөр таамаглалыг тодруулах**

Хүүхэд өөрт нь тохиолдсон боловч хэлж мэдэгдээгүй зүйл үлдсэн байж болзошгүй гэж таамаглан тодруулна. Дараах асуултын хувилбаруудыг асууж болно.

*Үүнтэй адил зүйл өөр хэн нэгэнд тохиолдсон уу?*

*Биеийн чинь бусад хэсэгт бидний яриагүй ямар нэг зүйл болж байв уу?*

## **В.11 Гэр бүлийн холбогдолтой асуулт**

Гэр бүлийн орчинд эсвэл хүүхдийн гэрт үе үе ирдэг хүн тухайн хэрэг зөрчлийг үйлддэг тохиолдолд гэр бүлийн холбогдолтой асуултыг асууна. Хүүхэд хариулахаас татгалзах, цааргалах байдалтай тохиолдолд ердийн сэдэв болгож асууж болно.

*Жишээ: Гэр бүлийн чинь талаар ярилцъя. Чи гэртээ ямар хүмүүстэй хамт амьдардаг вэ?*

*Жишээ: Чи тэр хүнтэй (сэжиг бүхий этгээд) байхдаа юу хийх дуртай ба дургүй талаараа ярьж өгнө үү.*

*Жишээ: Гэртээ байхад чамд хэцүү байдаг зүйл юу вэ? Ямар үед хэцүү, ямар үед тайван байдаг вэ?*

## **В.12 Бие махбодын аюулгүй байдлыг тодруулах**

**В.12.1** Энэ хэсгийн зорилго нь бэлгийн хүчирхийллийн тохиолдлын талаар дурдаагүй, эсвэл ярилцлага авч байгаа зорилгыг ойлгоогүй хүүхдээс мэдээлэл авахад чиглэнэ. Мөн хожим хойно хэн нэгэн биед нь зохисгүй хэлбэрээр хүрсэн нөхцөлд юу хийх талаар мэдлэг өгөхөд чиглэнэ.

**В.12.2** Эмчийн үзлэг, өөр гэрчийн ярилцлага зэрэгт тухайн хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй тохиолдолд, эсвэл хүүхэд өмнө нь энэ талаар дурдсан ч ярилцлагын үед үгүйсгэсэн тохиолдолд бие махбодын аюулгүй байдлын талаар хөндөж ярилцана.

## **В.13 Ярилцлагыг төгсгөх**

Ярилцлагыг дуусгахдаа дараах зааврыг мөрдөнө. Үүнд:

**В.13.1** Хүүхдэд талархснаа илэрхийлнэ.

*Жишээ: Чи өнөөдөр надад маш их зүйлийг ярьж өгсөнд их баярлалав.*

**В.13.2** Хүүхдийн үйлдлийг сайшаан дэмжинэ.

*Жишээ: Чи өнөөдөр надад өөрт тохиолдсон зүйлийг бүгдийг нь ярьсан нь тун сайн. Чи их зоригтой байсныг би хэлмээр байна. Ийм зүйл олон хүүхдэд тохиолддог ч олон хүүхдүүд энэ талаар бусдад хэлж чаддаггүй. Учир нь тэд айдаг. Чи ч гэсэн айсан байх. Гэхдээ энэ талаар бусад хүмүүст хэлж зоригтой байлаа.*

*Аав ээж чинь чамаар бахархах нь гарцаагүй. Би ч бас чамаар бахархаж байна.*

**В.13.3** Хүчирхийллийн тохиолдлыг цаашид хаана, хэрхэн мэдэгдэхийг тайлбарлана.

*Жишээ: Хэн нэгэн чамд таалагдахгүй, хүсэхгүй байдлаар биед чинь хүрвэл аль болох хурдан, аюулгүй байдлаар зугатаад чамд туслах боломжтой том хүнд хэлнэ. Чи тийм зүйл болвол хэнд хэлэх вэ?*

**В.13.4** Нэмэлт мэдээлэл, асуулт байгаа эсэхийг тодруулна.

*Жишээ: Чамд надад хэлмээр өөр зүйл байна уу?*

*Жишээ: Чамд надаас асуух ямар нэгэн асуулт байна уу?*

**В.13.5** Хүүхдэд эргэн холбоо барих мэдээллийг өгнө.

*Жишээ: Хэрвээ чи надтай дахин ярилцахыг хүсвэл энэ утсаар над руу холбогдоод дахин энд ирж надтай уулзаж болно. Хүүхдэд өөрийн нэр, утасны дугаарыг өгнө.*

## С Хавсралт (Мэдээллийн)

### HEEEADSSS аргаар хохирогч хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн байдлыг үнэлэх нь

Хүүхэд ялангуяа өсвөр насныхантай HEADSSS аргаар нийгэм сэтгэл зүйн байдлыг үнэлэхийг ДЭМБ -аас зөвлөмж болгосон байдаг. Энэ үнэлгээ нь хүүхэд өөрөө хэлээгүй, илэрхийлээгүй эрүүл мэндийн болон гэр бүл, орчны, нийгмийн асуудал, хүүхдийн зан үйл, эрсдэлт зан үйлийг илрүүлэхэд тустай.

Хүүхэд, өсвөр үеийнхний өөрсдийнх нь хэлсэн зовиур, мэдээллээс гадна тусгайлсан асуулт асуухгүй л бол бодит байдлаа огт хөндөхгүй, ярихгүй өнгөрөх магадлалтай. Айж, ичиж санаа зовсоноосоо болоод хэрэгцээт тусламжаа авч чадахгүй өнгөрөх тохиолдол ч гарахыг үгүйсгэхгүй.

Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон, жирэмсэн, жирэмсэн байж болзошгүй, хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй, амиа хорлох бодол, оролдлого, хорт зуршил байгаа зэргийг тооцож эрсдэлтэй гэж үзвэл шаардлагатай эмнэлгийн болон нийгэм сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэнд, хамгаалал, хуулийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах шаардлагатай болно.

|   | Эрсдлийн хүрээ  | Тодруулах асуултууд   |
|---|---|---|
| H | (Home)<br>Гэр бүлийн байдал   | Чи гэртээ хэнтэй хамт амьдардаг вэ? Гэр чинь хаана байдаг вэ? Чи гэртээ байх дуртай юу? Гэр чинь чиний хувьд аюулгүй, тайван газар мөн үү?                                      |
| E | (Education)<br>Боловсрол  | Чи сургуульд явдаг уу? Сургууль дээр чамд ямар байдаг вэ? Сургуульд явахад хүнд хэцүү зүйл байна уу? Хэрэв сургууль дээр чинь асуудал гарвал энэ үед чамд туслах хүн байгаа юу? |
| E | Employment/Ажил   | Чи ажил хийдэг үү, Тийм бол ямар ажил хийдэг вэ, Хийдэг ажил нь хүнд байдаг уу, Ажил дээр чинь ямар хүндрэл байдаг вэ?  |
| E | Eating/Хооллолт   | Чи хоол унд идсэн үү, Хоол ундандаа дуртай юу? Хоолтой холбоотой ямар нэгэн бэрхшээл байна уу?  |
| A | (Activities)<br>Үйл ажиллагаа   | Хичээлээс гадуур ямар үйл ажиллагаанд оролцдог вэ?  |
| D | (Drugs, alcohol and smoking)<br>Архи, согтууруулах ундаа, тамхи, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ | Чамд архи, тамхи хэрэглэдэг найз байдаг уу? Чи өөрөө эдгээрийг хэрэглэдэг үү? Хэн нэгэн чамд хүчээр эсвэл чамайг мэдээгүй байхад хэрэглүүлсэн тохиолдол байдаг уу?              |
| D | Depression/Сэтгэл гутрал  | Сэтгэл санааны байдал ямар байна вэ? Сэтгэл зовоосон ямар асуудлууд байна вэ?   |
| S | (Social media)<br>Нийгмийн сүлжээ   | Цахим орчинд чамд таагүй санагдахуйц ямар нэгэн зүйл болж байсан уу?  |
| S | (Suicide, Depression, Anxiety) Амиа хорлолт, сэтгэл гутрал, түгшүүр                             | Чамд сэтгэлээр унах, түгших мэдрэмж төрж байсан уу? Сэтгэл санаагаар унаж, санаа зовж түгших явдал тохиолддог уу?   |
| S | (Sexuality)<br>Бэлгийн харилцаа   | Чамд бэлгийн харилцаатай холбоотой санаа зовох зүйл эсвэл тусламж авах хэрэгцээ шаардлага байна уу?   |

**D хавсралт (норматив)**

**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫГ ЗАДРУУЛАХГҮЙ  
БАЙХ БАТАЛГАА**

(Маягт 2)

20... оны ...дугаар сарын ...-ны өдөр

Монгол Улсын иргэн..... регистрийн дугаартай,.....  
-ын ..... би албан тушаал, ажил үүргийн дагуу танилцсан,  
эсхүл мэдсэн төрийн болон албаны нууцыг чанд хадгалж, хамгаалахаа баталж  
байна.

Хэрэв би өөрт танилцуулагдсан төрийн болон албаны нууцыг задруулсан  
тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны хариуцлага хүлээхийг ухамсарлаж  
байна.

Баталгаа гаргасан: ...../...../  
*/гарын үсгийн тайлал/*

Баталгаа авсан:...../...../  
*/нууц хамгаалах ажилтан/*

## Е хавсралт (мэдээллийн)

### Бэлгийн хүчирхийллийн кейс менежментийн үе шатууд ба хэрэгжүүлэх үйл ажиллагаа

| Үе шат   | Кейс ажилтны хэрэгжүүлэх үйл ажиллагаа  |
|--|---|
| Үе шат 1.<br>Танилцах ба холбоо тогтоох                              | <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхэдтэй танилцаж, ая тухтай байдлыг бүрдүүлэх;</li> <li>• Хүүхэдтэй итгэлцэл бүхий холбоо тогтоох;</li> <li>• Кейс менежментийн үйл явцын талаар танилцуулж, таниулсан зөвшөөрөл авах;</li> </ul>  |
| Үе шат 2.<br>Нөхцөл байдлыг үнэлэх                                   | <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдэд тохиолдсон бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах;</li> <li>• Хүүхэд, хууль ёсны төлөөлөгчийн нөхцөл байдлыг үнэлж, хэрэгцээг нэн тэргүүний ба нэн тэргүүний бусаар ангилал</li> </ul>  |
| Үе шат 3.<br>Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний төлөвлөгөө гаргах | <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний төлөвлөгөөг хүүхэд, хууль ёсны төлөөлөгчтэй хамтран боловсруулах</li> <li>• Хүүхдийг бусад үйлчилгээнд холбон зуучлах тохиолдолд таниулсан зөвшөөрөл авах</li> </ul>   |
| Үе шат 4.<br>Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх, зохицуулах | <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийг тусламж үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх</li> <li>• Заавал мэдээлэх үүргийн дагуу холбогдох байгууллагад мэдээллийг дамжуулах</li> <li>• Хүүхдэд үзүүлэх үйлчилгээнүүдийг зохицуулах</li> <li>• Гэмт хэргийг хянан шийдвэрлэх үйл явцын талаар мэдээлэлтэй байх</li> <li>• Боломжтой бол хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх</li> </ul>            |
| Үе шат 5.<br>Үйлчилгээний явц, үр дүнг хянах, үнэлэх                 | <ul style="list-style-type: none"> <li>• Гэмт хэргийг хянан шийдвэрлэх үйл явцын талаар мэдээлэлтэй байх</li> <li>• Хүүхдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих</li> <li>• Шинэ хэрэгцээ, тулгамдсан асуудал гарч ирж буй эсэхэд хяналт тавих</li> <li>• Шаардлагатай бол үйлчилгээний төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлэх</li> <li>• Хүүхдэд гарч буй эерэг, сөрөг өөрчлөлт, үр дүнг үнэлэх</li> </ul> |
| Үе шат 5.<br>Кейсийг хаах  | <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн аюулгүй байдал хангагдаж байгаа эсэх</li> <li>• Төлөвлөгөөнд тусгасан зорилт, үр дүнд хүрсэн эсэх</li> <li>• Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан эсэх</li> </ul>   |

## Ашигласан материал

### Монгол улсын хуулиуд

1. Улсын их хурал.2011.Эрүүл мэндийн тухай хууль
2. Улсын их хурал.2011.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
3. Улсын их хурал.2013.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
4. Улсын их хурал.2013.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль
5. Улсын их хурал.2015.Эрүүгийн хууль
6. Улсын их хурал.2016.Хүүхдийн эрхийн тухай хууль
7. Улсын их хурал.2016.Төрийн болон албаны нууцын тухай хууль
8. Улсын их хурал.2016.Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
9. Улсын их хурал.2016.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
10. Улсын их хурал.2016.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль.
11. Улсын их хурал.2017.Цагдаагийн албаны тухай хууль
12. Улсын их хурал.2017.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
13. Улсын их хурал.2022.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
14. Улсын их хурал 2022.Шүүх шинжилгээний тухай хууль
15. Улсын их хурал.2023.Боловсролын ерөнхий хууль.
16. Улсын их хурал.2024.Хүүхэд хамгааллын тухай хууль

### Монгол улсын стандартууд

17. Нийгмийн ажлын дээд боловсролын стандарт. MNS5323:2009
18. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013
19. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 5852:2017
20. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6040:2019
21. Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага, MNS 6949:2021

### Журам, зааврууд

22. Эрүүл мэндийн яам, Хууль зүйн яам. 2012. Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам, А/356, А/182 дугаар тушаалын хавсралт
23. Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаалын хавсралт. Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам.
24. Хууль зүй, дотоод хэргийн яам. 2015. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам.
25. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2015. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам
26. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2015. Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журам.
27. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2015. Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах уулзалтыг зохион байгуулах журам
28. Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралт “Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа”
29. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам. 2017. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам. А/612 дугаар тушаалын хавсралт
30. Хууль зүй, дотоод хэргийн яам, 2017. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам. А/25 тушаал
31. Хууль зүй, дотоод хэргийн яам. 2017. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам,
32. Эрүүл мэндийн яам. 2017. Хохирогчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, 2017, А/394
33. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2017. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам.
34. Эрүүл мэндийн яам.2017. Хохирогчид сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх журам, А/394

35. Эрүүл мэндийн яам.2017. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл заслын, сэтгэл зүйн тусламж үзүүлэх журам, 2017, А/394
36. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/84/А/59/А/130 дугаар хамтарсан тушаалын хавсралт. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам.
37. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/305 дугаар тушаалын хавсралт. БЗДХ,ХДХВ/ДОХ -ын тусламж үйлчилгээ үзүүлэх заавар
38. Эрүүл мэндийн яам. 2018. Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж үйлчилгээ үзүүлэх заавар. А/364 дүгээр тушаалын хавсралт
39. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам.
40. Монгол улсын Засгийн газар. 2019. Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам, 220 тоот тогтоол
41. Эрүүл мэндийн яам. 2019. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм. А/406 дүгээр тушаалын хавсралт.
42. Эрүүл мэндийн яам. 2019. Үр хөндөлтийг зохицуулах журам. А/387 тушаалын хавсралт
43. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2020. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий мэргэжилтнийг давтан сургах хөтөлбөр, сургалт зохион байгуулах журам. А/149 тушаал
44. Эрүүл мэндийн яам. 2020. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, А/151 дүгээр тушаалын хавсралт
45. Эрүүл мэндийн яам. 2020. Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар, А/149 дүгээр тушаалын хавсралт
46. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/114 дүгээр тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах, тусламж үзүүлэх” (код 238) журам
47. Эрүүл мэндийн яам, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. 2020. Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ: эмнэл зүйн гарын авлага.
48. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалын хавсралт. Гэрч хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам
49. Эрүүл мэндийн яам. 2021. БЗДХ, ХДХВ, ДОХ-н тусламж үйлчилгээ үзүүлэх журам, А/305 тушаалын хавсралт
50. Эрүүл мэндийн яам. 2021. Өсвөр үеийн эрүүл мэндийн тандалт, эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн маягт, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны тусламж, урьдчилан сэргийлэх үзлэг, нэр томъёоны тайлбар, тандалтын мэдээллийн урсгалын журам, А/97
51. Эрүүл мэндийн яам. 2021. Хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зураглал батлах тухай, А/779
52. Эрүүл мэндийн яам. 2022. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар.
53. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 5 сарын 25-ны өдрийн А/110 дугаар тушаалын хавсралт. Хүүхэд хамгааллын бодлоыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар
54. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт. Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам
55. Монгол улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол. 2023. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн арван зургадугаар бүлгийн зарим зүйл, хэсэг (§16.3, §16.5)- ийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар
56. Монгол улсын ерөнхий прокурорын 2024 оны 12 сарын 23-ны өдрийн А/01 дугаар тушаалын хавсралт. Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага
- Ном, гарын авлага**
57. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага. 2003.Бэлгийн хүчирхийллийн хохирогчид эрүүл мэнд-хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх заавар.
58. Олон улсын авран хамгаалах хороо. 2012. Бэлгийн зүй бус харьцааг даван туулагч

- хүүхдүүдийг асран хамгаалах нь
59. Хүүхдийг Ивээх Сан. 2014. Удирдамж: Сэжиглэж буй зүй бус харьцаа, бэлгийн мөлжлөгийн кейстэй ажиллах нь. Лондон: Хүүхдийг Ивээх Сан
60. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэстний төв. 2018. Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчид үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ. Улаанбаатар хот.
61. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага ба НҮБ-ын Хүн Амын сан. НҮБ-ын Дүрвэгчдийн Дээд комисс. 2018. Хүчин ба дотно хамтрагчдын дунд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн клиник менежмент: хүмүүнлэгийн нөхцөлд баримтлах протокол.
62. Хүүхдийг Ивээх Сан. 2019. Хамтарсан багийн гишүүн өөрийн болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж.
63. Улсын ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төвийн Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлах хүрээлэн. 2019. Бага насны хүүхдийн эсрэг чиглэсэн бэлгийн хүчирхийллийн суурь судалгаа
64. Эрүүл мэнд, спортын яам, Хүчирхийллийн эсрэг Үндэстний төв, Нийгмийн эрүүл мэндийн хөгжил шинэчлэлийн хүрээлэн, Нэгдсэн үндэстний байгууллагын хүн амын сан. 2019. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төвтэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ.
65. Сешадри С, Рамасвами С. 2019. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд баримтлах клиник практикийн удирдамж. Энэтхэгийн Сэтгэцийн эрүүл мэндийн сэтгүүл.
66. Хүний Эрхийн үндэстний комисс, Цагдаагийн Ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Хүчирхийллийн эсрэг үндэстний төв, Хөөрхөн зүрх төрийн бус байгууллага, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан. 2020. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь (Цагдаагийн албан хаагчид зориулсан гарын авлага).(хэвлэгдээгүй)
67. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төсөл. 2020. Цагдаагийн байгууллагад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөмж.
68. Хүүхдийг Ивээх сан. 2020.Хүүхэд хамгааллын кейс менежментийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн гарын авлага. Улаанбаатар хот.
69. Хүүхдийг Ивээх Сан. 2020. Хамгааллын алхмууд. Кейс менежментийн нийтлэг арга зүй. Улаанбаатар хот.
70. Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага., IRIM судалгааны хүрээлэн. 2021. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа
71. Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан. 2022. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. (хэвлэгдээгүй)
72. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох аргачлал судалгаа. УБ
73. НҮБ-ын Хүүхдийн сан ба Олон улсын Авран хамгаалах байгууллага. Бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх удирдамж заавар. 2 дах хэвлэл. Нью-Йорк, 2023
74. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам. 2023. Бэлгийн хүчирхийллийн Хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй сэдэвт нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага (Боловсруулсан Х.Энхжаргал, Г.Ганбаясгах),
75. Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2023. Бэлгийн хүчирхийллийн кейс менежмент нийгмийн ажлын холбон зуучлах үйлчилгээний арга зүй. Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан гарын авлага. (Боловсруулсан: Энхжаргал.Х. Анагаах ухааны доктор)
76. Хүүхдийг Ивээх сан. 2023. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч, даван туулагсдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ. Модуль 11. Улаанбаатар хот. (Боловсруулсан: Д.р. Зууннастын Хишигсүрэн, Даваасүрэнгийн Оюунсүрэн)
77. Хүүхдийг ивээх сан. 2023. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох нь. (Боловсруулсан Г.Түмэннаст, доктор)
78. Хүүхдийг ивээх сан. 2023. Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ. (Боловсруулсан А.Хонгорзул, Г.Түвшинжаргал, П.Энхчимэг)
79. Хүүхдийг ивээх сан. 2023.Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нэг цэгийн



- үйлчилгээний төв болон хамгаалах байрны үйлчилгээ. (Боловсруулсан М.Чанцалсүрэн)
80. Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2023. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй. (Боловсруулсан Х.Энхжаргал, Г.Ганбаясгах)
81. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан. 2023. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний зураглал (байгууллагын хэрэгцээнд). (Боловсруулсан С.Энхтуяа, хүүхэд хамгааллын зөвлөх)
82. Азийн Хөгжлийн банк. 2023. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхэдтэй ажиллах сэтгэл зүйн цогц үйлчилгээний хөтөлбөр. Сэтгэл зүйч, мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. (Боловсруулсан Д.Цогзолмаа., С.Нандин-Эрдэнэ.)
83. Азийн Хөгжлийн банк. 2023. Амиа хорлох эрсдэл бүхий өсвөр насны хүүхэдтэй ажиллах сэтгэл зүйн цогц үйлчилгээний хөтөлбөр. Сэтгэл зүйч, мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. (Боловсруулсан Д.Цогзолмаа., С.Нандин-Эрдэнэ.)
84. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. 2024. Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм.

ТӨСӨЛ